



*Empowered lives.  
Resilient nations.*

# МОНГОЛ УЛСАД ҮЗҮҮЛСЭН СОНГУУЛИЙН ТУСЛАЛЦААНЫ СУРГАМЖ 2008-2012

Улаанбаатар хот



*Empowered lives.  
Resilient nations.*

Хаяг: НҮБ-ын Суурин төлөөлөгчийн газар  
Нэгдсэн Үндэстний гудамж-12  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201  
Монгол улс  
Утас: +976 11 327585  
Факс: +976 11 326221  
И-мэйл: [registry.mn@undp.org](mailto:registry.mn@undp.org)



*Empowered lives.  
Resilient nations.*

# МОНГОЛ УЛСАД ҮЗҮҮЛСЭН СОНГУУЛИЙН ТУСЛАЛЦААНЫ СУРГАМЖ

## 2008 - 2012

Улаанбаатар  
2013

## **МОНГОЛ УЛСАД ҮЗҮҮЛСЭН СОНГУУЛИЙН ТУСЛАЛЦААНЫ СУРГАМЖ 2008-2012**

Энэ тайланг бие даасан зөвлөх Пол Гуэрин (Paul Guerin) бэлтгэв. Ноён Гуэрин нь НҮБ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Ардчилал, сонгуулийн туслалцааны олон улсын хүрээлэн (IDEA), Сонгуулийн туслалцааны олон улсын сан (IFES), Европын холбоо, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын (OSCE) нэрийн өмнөөс Ази, Африк, Араб, Зүүн Европын шинэ тулгар ардчилсан 30 гаруй оронд сүүлийн 20 жил ардчилал, сонгуулийн туслалцааны чиглэлээр ажиллажээ. Тэрээр сонгууль зохион байгуулахаас эхлээд сонгуулийн хороодод зөвлөгөө өгөх, иргэний нийгэмтэй хамтран ажиллах, сонгуулийн ажиглалт хийх, сонгуулийн туслалцааны хөтөлбөрт үнэлгээ өгөх зэрэг төрөл бүрийн үүрэг гүйцэтгэжээ.

Зохиогчийн эрх © 2013

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр

Энэ баримт бичигт туссан үзэл бодол, дүгнэлт, санал нь НҮБХХ, түүний Гүйцэтгэх зөвлөл, Гишүүн орнуудынх биш юм. Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

НҮБХХ-өөс урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр энэ баримт бичгийг бүхлээр нь, эсвэл хэсэгчлэн цахим, механик, хуулбарлах, бичлэг хийх болон бусад аль ч хэлбэрээр дахин хэвлэх, аливаа системд хадгалах, дамжуулахыг хориглоно.

## ГАРЧИГ

|  |    |
|--|----|
| <b>ТОВЧ АГУУЛГА</b> .....  | 4  |
| <b>1. ОРШИЛ</b> .....  | 6  |
| <b>2. УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 ОНЫ СОНГУУЛИЙН ШИНЭТГЭЛ</b> .....                                   | 7  |
| 2.1. Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ).....   | 7  |
| 2.2. Сонгогчийн бүртгэл .....  | 8  |
| 2.3. Жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог хангах .....                    | 8  |
| 2.4. Улс төрийн намын сонгуулийн сурталчилгааны санхүүжилт .....                               | 10 |
| 2.5. Сонгогчдын саналыг татах зорилгоор төрийн албан тушаал ба төсвийн хөрөнгийг ашиглах ..... | 11 |
| 2.6. Санал авах ажиллагаа .....  | 11 |
| 2.7. Сонгогчдын оролцоо.....   | 12 |
| 2.8. Гадаадад суугаа иргэдийн саналыг авах.....  | 13 |
| 2.9. Санал тоолох ажиллагаа.....   | 14 |
| 2.10. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх .....  | 14 |
| 2.11. Сөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх .....  | 15 |
| 2.12. Хэвлэл мэдээлэл.....   | 15 |
| 2.13. Төрийн бус байгууллагын мониторинг.....  | 16 |
| 2.14. Орон нутгийн сонгууль.....   | 16 |
| 2.15. НҮБХХ-ийн үүрэг .....  | 17 |
| <b>3. ДҮГНЭЛТ</b> .....  | 17 |
| <b>4. СУРГАМЖ</b> .....  | 18 |
| <b>5. ЗӨВЛӨМЖ</b> .....  | 20 |
| <b>ХАВСРАЛТ 1: Ярилцлага өгсөн хүмүүсийн нэрс</b> .....  | 22 |

## ТОВЧ АГУУЛГА

Улсын Их Хурлын 2008 оны сонгууль олон маргаан, үймээн самуун дагуулсны эцэст сонгуулийн тогтолцоог шинэчлэх улс төрийн хүсэл зориг Монгол улсад анх удаа бүрджээ. Сонгуулийн тогтолцоог шинэчлэх хэлэлцүүлэг 2010 оноос эхэлсэн боловч УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг сонгууль болохоос зургаан сарын өмнө буюу 2011 оны 12 сарын 15-нд баталжээ. Эдгээр өөрчлөлтөд тухайн тойрогт хамгийн олон санал авсан нь сонгогдох 48, намын жагсаалтаар хувь тэнцүүлэн сонгогдох 28 суудал бүхий сонгуулийн паралель тогтолцоог баталсан, сонгогчдын шинэчилсэн жагсаалтыг хүн амын шинэчилсэн бүртгэл дээр үндэслэн Улсын бүртгэлийн ерөнхий газраас баталгаажуулан иргэний шинэ үнэмлэх олгосон, саналын хуудсыг автомат машинаар тоолсон, төрийн бус байгууллагууд санал авах, санал тоолох ажиллагааг ажиглах эрхтэй болсон, гадаад улсад байгаа иргэдийн саналыг авах зэрэг шинэ зүйлс орсон юм.

Олон шинэ зүйлийг нэвтрүүлсэн, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа бага байсан хэдий ч Улсын Их Хурлын 2012 оны 6 сарын сонгууль зөрчилгүй, онцгой тайван болж өнгөрөв. Шинэтгэлийн үр дүнд мөн оролцоо сайжирч, сонгогдсон эмэгтэйчүүд болон бие даан нэр дэвшигчийн тоо нэмэгдсэн, сонгогчдын бүртгэл илүү үнэн зөв хийгдэж, сонгуулийн дүн хурдан гарсан бөгөөд түүнийг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрчээ. Ерөнхийдөө сонгогчид сонгуулийн шинэ тогтолцоо, түүний дотор саналын шинэ хуудас, автомат машин хэрэглэхэд төөрөлдөөгүй бөгөөд сонгогч буруу тэмдэглэл хийснээс хүчингүй болсон саналын хуудас 3.6 хувь байв.

Эдгээр ололт амжилтын зэрэгцээгээр сайжруулах зүйл ч багагүй байна. Сонгуулийн ерөнхий хороонд сонгуулийг үр нөлөөтэй зохион байгуулах, сонгогчдын боловсролын хөтөлбөрийг зохих ёсоор хэрэгжүүлэх хангалттай хугацаа олгохын тулд хуулийн нэмэлт өөрчлөлтийг эрт хийж байх нь зүйтэй юм. Хугацаа давчуу байсны улмаас иргэний ухаалаг үнэмлэхийг хугацаанд нь тарааж амжаагүй зэрэг дутагдлууд гарав.

Эмэгтэй нэр дэвшигчдийн 20 хувийн квот тогтоосон нь сайшаалтай боловч УИХ дахь эмэгтэй төлөөлөгчдийн тоо зөвхөн 3-аас 11 болж нэмэгдсэн. Цаашид намын жагсаалтад эмэгтэй нэр дэвшигчдийг байрлуулах журам, улс төрийн намын тухай хуульд квотыг тодорхой зааж өгөх нь тустай байх болно. Түүнчлэн эмэгтэй нэр дэвшигчдийн хувьд нэг мандаттай тойрогт өрсөлдсөнөөс олон мандаттай тойрогт өрсөлдөх нь (эрэгтэй нэр дэвшигчтэй баг болон) тэдний сонгогдох боломжийг нэмэгдүүлж болох нь харагдлаа.

НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр сонгогчдод чиглэсэн хэвлэл мэдээллийн кампанит ажил явуулсан нь үр дүнгээ өгсөн бөгөөд сэтгүүлчдийн дунд жендэрийн мэдрэмжтэй мэдээ сурвалжлага бэлтгэх сургалт явуулснаар байдал сайжирсан боловч энэ чиглэлээр цаашид хийх зүйл их байна. УИХ дахь Эмэгтэйчүүдийн бүлгээр дамжуулан эмэгтэй гишүүдийг дэмжих замаар асуудлыг гаргаж тавих нь тустай ч жендэрийн мэдрэмжтэй хууль батлах, хороо байгуулах, журам гаргах, төсөв боловсруулахад парламентын эрэгтэй гишүүдийн жендэрийн мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Сонгуулийн сурталчилгааны санжүүжилт асуудалтай хэвээр байна. Улс төрийн намууд нэр дэвшигчдээс мөнгөн хандив авахын зэрэгцээ сурталчилгааны зардлыг нэр дэвшигчид хувиасаа санхүүжүүлж байна. Зарим нэр дэвшигч, ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд хөрөнгө босгох нь хүндрэлтэй байж болох юм. Иймд улс төрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай хуулийн төслийг боловсруулж, хэрэгжилтэд нь сайтар хяналт тавих, хууль зөрчсөн үйлдэлд тухай бүр шийтгэл ногдуулж байх шаардлагатай. Хүчтэй хязгаарлалт тогтоохгүй байх нь мөнгөтэй нэр дэвшигчид болон улс төрийн намуудад сонгуульд ялах боломжийг нээж өгч буй хэрэг юм. Хяналт байхгүй, хууль мөрдөхгүй байснаар улс төрийн намууд, парламентын гишүүд сонгогдсоныхоо дараа бизнесийн ашиг сонирхлын нөлөөнд автах, албан тушаал амлах, эсвэл тендерт ялуулах зэргээр улсын хөрөнгө нөөцийг зүй бус зарцуулах явдал хяналтаас гадуур өнгөрч болно.

Сонгогчид болон улс төрийн намуудад ногдуулах шийтгэл байгаа ч санал худалдан авах явдал гарсаар, ажилгүйдэл өндөр, цалин бага нөхцөлд үүнийг бүрмөсөн арилгахад хүндрэлтэй байна. Иргэний боловсролоор дамжуулан саналын үнэ цэнийг сонгогчдод тайлбарлан ойлгуулах, намуудад зохих шийтгэлийг ногдуулах арга хэмжээг цаашид үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

СЕХ улс төрийн намууд, иргэний нийгмийн байгууллагуудтай тогтмол уулзаж, тэдний санал бодлыг сонсч байх нь ил тод байдлыг нэмэгдүүлэх, харилцан ойлголцлыг сайжруулах, зөрчилдөөнөөс сэргийлэх ач холбогдолтой юм. Үүний зэрэгцээ сонгуулийн сурталчилгааны санхүүжилт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд үр нөлөөтэй хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх СЕХ-ны чадавхийг бэхжүүлэх хэрэгтэй байна.

Эцэст нь, дотоод, гадаадад сонгуулийн ирц доогуур байгаа учир шалтгааныг СЕХ ба улс төрийн намууд аль аль нь олж тогтоох нь зүйтэй юм. Улс төрийн намууд мөн сонгогчид, ялангуяа улс төрийн үйл явцад сэтгэл алдарсан, түүний гадна үлддэг залуу сонгогчдыг идэвхжүүлэхэд анхаарах хэрэгтэй.

## 1. ОРШИЛ

2008 он хүртэл сонгогчдын бүртгэл сул, санал тоолох ажиллагаа будлиантай, санал худалдаж авах явдал түгээмэл байсан бөгөөд хууль зөрчсөн тохиолдолд ногдуулах шийтгэл бага, жендэрийн квотгүйн улмаас УИХ-д гуравхан эмэгтэй сонгогдсон дүр зурагтай явж иржээ. Шинэтгэл шаардлагатай байсан, тус шинэтгэлийг ч хэрэгжүүлэв.

2008 оны сонгуулийн дараа шинэтгэл шаардлагатай болохыг талууд нийтээр хүлээн зөвшөөрсөн ч улс төрийн хоёр гол нам болох Монгол ардын нам ба Ардчилсан нам сонгуулийн тогтолцооны талаар удаан маргалдсаны эцэст 2011 оны 12 дугаар сард талууд зөвшилцөлд хүрч, гишүүдийн гуравны хоёр нь тойрогт өрсөлдөх, гуравны нэг нь намын жагсаалтаар сонгогдох хувилбар дээр тогтжээ.

2011 оны 12 сард батлагдсан УИХ-ын сонгуулийн тухай хуульд сонгуулийн тогтолцоо болон сонгуулийг зохион байгуулахтай холбогдсон чухал заалтууд туссан. Үүнд: 1) мажоритор тогтолцооноос холимог/паралель тогтолцоо руу шилжсэн (76 суудлын 48 нь тойргоос, 28 нь намын жагсаалтаас сонгогдох); 2) эмэгтэй нэр дэвшигчдэд 20 хувийн квот олгосон; 3) санал тоолохдоо автомат машин ашигласан; 4) анх удаагаа гадаад улсад байгаа монгол иргэд саналаа өгсөн; 5) сонгуулийн хороо, хэсгүүдэд улс төрийн намуудын төлөөлөл бус төрийн албан хаагчид ажилласан; 6) ухаалаг иргэний үнэмлэх ашиглахаар төлөвлөж байсан боловч хэвлэх, тараах ажиллагаа удааширснаас УИХ-ын сонгуульд бүрэн ашиглаж чадаагүй, 2012 оны 11 дүгээр сард болсон орон нутгийн сонгуульд ашигласан; 7) сонгогчдын нэрсийн жагсаалтыг сонгуулийн хэсгийн хороод биш, Улсын бүртгэлийн ерөнхий газар дангаар хариуцан гаргасан зэрэг болно. Түүнчлэн нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийг УИХ-ын сонгуультай хамт зохион байгуулсан юм.

Эдгээр арга хэмжээ нь өмнөх сонгуулиудад гарч байсан дутагдлууд, тухайлбал, сонгогчдын бүртгэл будлиантай, гараар санал тоолох ажиллагаа уддагаас сонгуулийн дүнг зарлах ажиллагаа удааширдаг, улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо бага зэрэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн юм.

Дээрх шинэчлэлүүд хийгдсэн ч сонгуулийн ба улс төрийн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд чиглэсэн олон асуудлыг хэлэлцэх, хуулийн төсөл боловсруулахаар УИХ төлөвлөөд байна. Хуулийн эдгээр төсөл нь сонгуулийн хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх, Монгол улсын улс төрийн тогтолцооны төлөөлөл, оролцоог нэмэгдүүлэх зорилготой. Санал болгож байгаа хоёр хууль буюу Улс төрийн намын тухай хууль ба Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төсөл нь иргэдийн сонгуульд албан тушаалд өрсөлдөх боломжийг өргөжүүлэхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд чиглэж байгаа бол, сонгуультай холбоотой бүх хуулийг нэгтгэн сонгуулийн



нэгдсэн хуультай болох санал нь УИХ-ын, ерөнхийлөгчийн болон орон нутгийн сонгуулийн хоорондын уялдааг сайжруулах, өнөөгийн хууль эрх зүйн зохицуулалтыг хялбаршуулахад чиглэж байна. Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх талаар шүүх байгууллагуудын эрх мэдэл, харьяалал тодорхойгүй, хуулийн хэрэгжилт, холбогдох дүрэм журмын талаар олон нийтийн мэдлэг дутмаг байгаа зэрэг нь Монгол улсад хийгдэж буй сонгуулийн ба улс төрийн шинэчлэлийн нааштай үр дүнг баллах боломжтой гэдгийг анхаарвал зохино.

2010-2011 онуудад хийгдсэн шинэчлэлийн үйл явцаас холбогдох талуудын хөндсөн асуудал нь хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэх явцад талуудын оролцоог хангах, зөвлөлдөх үйл ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байгааг онцоллоо. Ийнхүү зөвлөлдөх нь парламентын гишүүдийн тэргүүлэх үүрэг оролцоог тэднээс салгах бус, харин шинэтгэл хийхэд иргэд болон тодорхой бүлгүүдийн оролцоог өргөжүүлснээр бүхий л үйл явц, үр дүнг бэхжүүлэх ач холбогдолтой.

## **2. УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 ОНЫ СОНГУУЛИЙН ШИНЭТГЭЛ**

### **2.1. Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ)**

Өмнөх сонгуулиудтай харьцуулахад СЕХ-ны нэг намын талыг баримтлах нь багассан гэж байгаа боловч нэр дэвшигчдийг бүртгэх, улс төрийн санхүүжилтийг хянах, хууль зөрчсөн тохиолдолд шийтгэл ногдуулах зэрэгт улс төрийн нөлөөллөөс хамгаалах хамгаалалт цаашид шаардлагатай байна. СЕХ-ны гишүүний 5-ыг УИХ, 2-ыг Ерөнхийлөгч, 2-ыг нь Дээд шүүх дэвшүүлдэг. СЕХ-ноос намуудтай тулж ажиллах, зөрчилдөөнийг шийдвэрлэх чадавхиа сайжруулах, талуудтай тогтмол уулзалт хийх, гаргасан шийдвэрээ хамгаалахын тулд хуулийг баримталж ажиллахад анхаарах хэрэгтэй.

Зарим ажиглагч сонгуулийн луйвар байгаа эсэхийг нягтлахын тулд санал авах хэсгийн албан ёсны дүнг цаг цагаар зарлаагүй, мөн бүрэн тайлан хэвлэдэггүй учраас вэбсайт дээр мэдээлэл байрлуулах замаар СЕХ илүү ил тод ажиллах шаардлагатай хэмээн мэдээлэв.

2012 оны 11 сард болсон орон нутгийн сонгуулиар олон нэр дэвшигч бүртгэгдсэн, олон төрлийн саналын хуудас хэвлэх, санал тоолох машины програмчлалыг хийх зэргээр сонгуулийн байгууллагын чадавхийг дахин сорьсон сонгууль болж өнгөрлөө. Эдгээр сорилт болон хугацаа бага байсан ч сонгуулийг амжилттай зохион байгуулжээ.

## **2.2. Сонгогчдын бүртгэл**

Өмнөх сонгуулиудад бүртгэлтэй холбоотойгоор сонгуулийн луйвар хамгийн их гардаг гэсэн ойлголт байсан бөгөөд ялангуяа УИХ-ын 2008 оны сонгуульд сонгогчдыг давхардуулан бүртгэсэн тухай асуудал гарч сонгуулийн дүнд үл итгэхэд нөлөөлсөн.

Энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газарт (УБЕГ) сонгогчдын нэрсийн жагсаалт гаргах үүргийг хүлээлгэсэн. 2012 оны сонгогчдын нэрийн жагсаалт сайжирсан боловч сонгогчдын нэрийг хоёр дахин бичсэн, өөр хаяг дээр бүртгэсэн зэрэг тохиолдол гарав. Иргэний бүртгэлтэй холбоотой ихэнх гомдол нь хаягийн зөрүүтэй холбоотой байжээ. Иргэн шинэ хаяг руу шилжихдээ тэндээ бүртгүүлдэг боловч хуучин хаягийн бүртгэлээсээ хасуулдаггүй нь нэг хаяг дээр давхардуулан бүртгэхэд хүргэдэг байна.

Иргэний бүртгэлийг шинэчлэх ажил 2010 оноос эхэлж, ухаалаг иргэний үнэмлэхийг 2012 онд үйлдвэрлэж эхэлсэн боловч сонгуулиас өмнө бүрэн тарааж амжаагүй учир сонгогчдын ихэнх нь хуучин үнэмлэх, сонгуулийн бүртгэлийн баримт бичгээ ашигласан бөгөөд үүнийг нэрийн жагсаалттай тулгасан. Цаашид бүх сонгогч ухаалаг иргэний үнэмлэхтэйгээ санал авах хэсэгт ирж, тэнд шууд уншуулах боломжтой болох юм. Ингэснээр 2012 оны сонгуулийн үеэр гарсан хаяг зөрөх явдлаас сэргийлж чадна. УБЕГ-ын мэдээлснээр сонгогчдын 96 хувь нь орон нутгийн сонгуулиас өмнө иргэний шинэ үнэмлэхээ авсан байна.

Сонгогчдын хаягийг үндэслэн сонгуулийн нэг хэсэгт ногдох тоог 1800 хүртэл нэмэгдүүлсэн бөгөөд хэрэв сонгогчдын санал өгөх хэсэг өөрчлөгдсөн бол тэдэнд мэдээлэх нь чухал. Шинэ хуулиар хорооны иргэний бүртгэлийн ажилтан сонгогчдын хэсгийн хуваарийг хийсэн бөгөөд [www.burtgel.mn](http://www.burtgel.mn) сайт, эсвэл хэвлэсэн жагсаалтаас нэрээ нягтлахыг иргэдээс хүссэн.

## **2.3. Жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог хангах нь**

Эмэгтэй нэр дэвшигчдийн 20 хувийн квотыг 2012 оны сонгуульд хэрэгжүүлсэн. Гэхдээ эмэгтэйчүүд УИХ-ын гишүүдийн дөнгөж 14.5 хувийг эзэлж байгаа нь Монгол улс дэлхийн дундаж үзүүлэлт – 20.5 хувиас доогуур байна. Иймд квот нэвтрүүлснээр хүссэн үр дүнд хүрээгүй, эмэгтэйчүүдийн эзлэх суудал дөнгөж 8-аар нэмэгдэв.

Эмэгтэйчүүдийн хувьд намын жагсаалтаар төдийгүй тойргоос сонгогдох боломжийг нь нэмэгдүүлэх шаардлагатай байна. Олон мандаттай тойрог үүнийг шийдвэрлэх нэг арга зам байж болох юм. Зарим нам эмэгтэй нэр дэвшигчдээ жагсаалтад дээгүүр эрэмбэлсэн байхад зарим нь доогуур

эрэмбэлсэн, эмэгтэйчүүдийн сонгогдох боломжийг нэмэгдүүлэх зохицуулалт байхгүй байна.

Жендэрийн үндэсний хороо, НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр, “Эмэгтэйчүүд чадна” хэвлэл мэдээллийн кампанит ажил явуулсан нь эмэгтэйчүүд хүчтэй гэдгийг харуулахад тус болсон. Гэхдээ хэвлэл мэдээллээр парламентын эмэгтэй гишүүдийн хийсэн ажил, үр дүнг илүү сурталчлах хэрэгтэй байна. Парламентын эрэгтэй гишүүд хууль эрх зүйн шинэчлэлийн талаар хийж байгаа ажлаараа олон нийтэд танигдах нь илүү боловч “хөшигний ард” эмэгтэйчүүдийн оруулж байгаа хувь нэмэр эн тэнцүү байж болно. Иймээс сонгогчид эрэгтэй нэр дэвшигчдийг илүү үр бүтээлтэй улс төрчид гэж үзэх хандлагатай байдаг. Үүний зэрэгцээ НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр эмэгтэй нэр дэвшигчдийг нийтэд таниулах зорилгоор сэтгүүлч сурвалжлагчдад зориулсан гурван үе шаттай сургалт зохион байгуулж, эмэгтэй улстөрчдийг нас, гэр бүлийн статус, төрх байдлаар нь алагчлахгүй байх талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах гэрээ байгуулжээ.

Эмэгтэйчүүд өөртөө итгэлгүй, мөнгө санхүүгээр дутмаг байдгийн улмаас сонгуульд өрсөлдөх сонирхолгүй байдаг тул нэг нэр дэвшигч санаачлан “Микрофон ба индэр” нэртэй сургалтыг сонгуульд нэр дэвших сонирхолтой эмэгтэйчүүдэд зориулан зохион байгуулж, тэдэнд нийгмийн харилцааны хэрэгслээр дамжуулан өөрийгөө хэрхэн таниулах, намын хорооны хурал дээр санаа бодлоо хэрхэн илэрхийлэх, индэр, микрофонийг хэрхэн эзэмших, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцах, өгүүлэл бичих, тодорхой ярьж сурах, имижээ харуулах, товчхон хариулах, дуугүй байх гэх мэт асуудлаар долоо хоног бүр хичээл заажээ. Эмэгтэйчүүд жижиг арга хэмжээнд улстөрчийн хувьд оролцож үг хэлэх, бодлогын асуудалд хариулах зэргээр сонгуулийн том сурталчилгаа эхлэхээс өмнө ур чадвараа сорьж сургуулилт хийжээ.

УИХ-д сонгогдсон 11 эмэгтэйн 3-аас бусад нь шинэ гишүүд тул тэдэнд УИХ-ын үйл ажиллагаа, гишүүний үүргийн талаар чадавхийг нь бэхжүүлэх, төсөв, хуулийн төсөл боловсруулах, байнгын хороодын ажиллагаа, олон нийттэй харилцах, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах, эмэгтэй гишүүдээс олон нийтийн хүлээж буй хүлээлтийг хэрхэн зохицуулах зэргээр сургалт шаардлагатай байна.

2011 онд хийгдсэн сонгуулийн шинэчлэл, квотын үр дүнд сонгогдсон эмэгтэй гишүүд УИХ-д эмэгтэйчүүдийн албан бус бүлэг байгуулж, өөр өөр намын харьяалалтай ч УИХ дотор жендэрийн асуудлаар хамтран ажиллахаар тохиролцоод байна. Эмэгтэй гишүүд нийтлэг зорилгодоо хүрэхийн тулд намуудын байр суурийг нэгтгэх, хууль батлах явцад эрэгтэй гишүүдтэй хамтарч ажиллах тодорхой сорилтууд тулгарч байна. Бусад орны парламентын эмэгтэй гишүүдтэй харилцаа холбоо тогтоож, тэдний туршлагаас суралцах нь чухал.

Сонгуулийн өмнөх санал асуулгаар сонгогчид эмэгтэйчүүдийн төлөө саналаа өгөх дүн гарсан нь улс төрийн намууд хоёр мандаттай тойрогт эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэхэд нөлөөлсөн байж болно. Эмэгтэйчүүд авлигад бага өртдөг хэмээн олон нийт үздэг тухай зарим хүн уулзалтын үеэр ярьсан боловч энэ нь нотолгоогүй зүйл юм.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх асуудлыг Азийн Бүсийн бага хурлын үеэр хөндөж, дараа нь Бүс нутгийн семинарт оролцсон УИХ-ын эмэгтэй гишүүд, засгийн газар, улс төрийн нам, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн төлөөлөгчид “Сонгуульт албан тушаалд улс төрийн тэгш оролцоог хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг” боловсруулсан. Улс төрийн гол намууд энэ төлөвлөгөөг дэмжихээ илэрхийлээд байна. Олон улсын хамтын нийгэмлэг бүс нутгийн парламентын эмэгтэй гишүүдтэй холбоо тогтоох иймэрхүү уулзалтыг дэмжиж ажиллах нь зүйтэй.

Жендэрийн эрх тэгш байдлын тухай ярихдаа зөвхөн тоон төлөөлөлд анхаарч, жендэрийн асуудлыг бодлогод тусгаж хэрэгжүүлэх талаар хийсэн зүйл бага байна. УИХ-ын гишүүд, байнгын хороодын ажилтнуудыг жендэрийн мэдрэмжтэй хууль, төсөв боловсруулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар сургалтанд хамруулах нь үр дүнтэй ажил болно.

## **2.4. Улс төрийн намын сонгуулийн сурталчилгааны санхүүжилт**

Улс төрийн намууд нэр дэвшигчдийг ардчилсан зарчмаар сонгодоггүй, намын дүрэмд стандарт квот байдаггүй, “нэр дэвшигчийн татвар” авч ялгавартай байдал бий болгодог нь тэдний дотоод ардчилал сул байгааг харуулж байна. Үүний зэрэгцээ нэр дэвшигч сонгуулийн сурталчилгааныхаа зардлыг санхүүжүүлэх шаардлагатай болдог. Энэ шалтгааны улмаас парламентын гишүүдийн дунд бизнес эрхлэгчдийн тоо нэлээд өндөр байна. Улс төрд бизнесийн ашиг сонирхлын нөлөө ордог, том компаниудын мөнгө сонгуулийн сурталчилгааны зардлыг санхүүжүүлэх хэрэгсэл болж байгаа нь төлөөллийн мөн чанарыг алдагдуулж байгаа тул энэ байдлыг даруй таслан зогсоох хэрэгтэй. Бизнесийн эдгээр бүлэг нь засгийн газраас зарлаж байгаа уул уурхайн ба дэд бүтцийн томоохон төслийн тендерт ялах, нөлөөлөл үзүүлэх, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан засгийн газарт шахалт үзүүлэх хандлагатай байдаг.

Одоогийн тогтолцоо нь бизнестэй холбоотой, албан тушаал эрхэлж буй хүмүүс хэлхээ холбоогоороо дамжуулан санхүүжилт босгоход үйлчилж, хэлхээ холбоогүй, ялангуяа эмэгтэйчүүд, эсвэл жижиг намаас нэр дэвшигчдэд саад тотгор болж байна. Одоогоор сонгуулийн сурталчилгааны зардалд өгөх хандивын хэмжээнд тогтоосон бодит хязгаарлалт байхгүй, ил тод мэдээлэх заалт хэрэгжихгүй байна. Иймд улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийг сайжруулах шаардлагатай бөгөөд улсын төсвөөс санхүүжүүлэх хувилбар нь энэ асуудлыг шийдвэрлэх боломж гэж

зарим хүмүүс үзэж байна. Улс төрийн намуудаас тогтоож байгаа энэ шударга бус “нэр дэвшигчийн татвар”-ын хэмжээ нь маш өндөр учраас намын дотор татварыг төлөх, төлөхгүй нэр дэвшигчид гарч зөрчил үүсгэдэг байна.

Нэг нааштай алхам бол СЕХ сонгуулийн сурталчилгаатай холбоотой дүрэм журмыг өмнөх сонгуулиудаас илүү чанд мөрдүүлж ажилласан явдал байлаа. Улс төрийн намуудаас эдийн засгийн хувьд биелэх боломжгүй амлалт авахуулахгүй байх зорилгоор намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг Үндэсний аудитын газраар хянасны дараа хүлээн авах шаардлага тавьсан. Намууд эдгээр мөрийн хөтөлбөрийн хүрээнд сурталчилгаагаа хийв.

## **2.5. Сонгогчдын саналыг татах зорилгоор албан тушаал, төсвийн хөрөнгийг ашиглах нь**

УИХ-ын 2008 оны сонгууль, 2009 оны нөхөн сонгуулийн сурталчилгааны үеэр сонгогчдын саналыг татах зорилгод төрийн албан тушаалыг ашигласан болон бусад булхай гарсан тухай мэдээлэл гарч иргэдийн сонгуулийн дүнд үл итгэх байдлыг улам бүр нэмэгдүүлжээ.

Сонгогчид гадны аливаа нөлөөгүйгээр сонголтоо хийх эрхтэй. Зарим нэр дэвшигч, улс төрийн нам сонгогдвол ажлын байр, албан тушаал, жижиг тэтгэлэг олгох зэрэг амлалт хийдэг тухай яригддаг. Эдгээр мэдээллийн үнэн худал тодорхойгүй боловч ялангуяа хөдөө орон нутагт ажлын байр хомсдолтой байдаг нь том хөшүүрэг болж, хэн нэгний ивээлд багтах, эрх мэдлээ урвуулан ашиглах нөхцөлийг бий болгодог. Сонгогчдын саналыг татах зорилгоор элдэв амлалт авах, үйл ажиллагаа явуулахыг хориглосон, хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгасан олон заалт орсон бөгөөд хуулийг чанд мөрдсөнөөр энэ явдлыг зогсоож чадах юм.

Санал худалдах явдлыг багасгах зорилгоор зөвхөн нэр дэвшигчид, улс төрийн намууд төдийгүй, бас сонгогчидтой хариуцлага тооцох болжээ. Сонгуулийн сурталчилгааны мэдээллүүдэд санал авах хэсэгт саналын хуудас авч орох, хуурамч бичиг баримт ашиглах, саналын хуудасны тэмдэглэгээ хийсэн гэрэл зургийг авах, бусдад харуулах зэрэг сонгогчдод хориглосон зүйлийг жишээ болгон тавьжээ.

## **2.6. Санал авах ажиллагаа**

2008 оны сонгуульд саналын хуудастай холбоотой гарсан шүүмжлэл нь хэвлэх явц ил тод бус, хяналт тавих боломжгүй, сонгуулийн ажиглагчдад саналын хуудасны гол нууцлал болох усан хээг ажиглах боломж олгоогүй, зэрэг дутагдлууд байлаа. Харин 2012 оны сонгуулийн хувьд дотоодын ажиглагчид хэвлэх явцыг 24 цагийн турш ажигласан байна.

Санал хураахдаа саналын хуудасны нэг талд нь тойргоос нэр дэвшигчдийг, нөгөө талд нь намын жагсаалтыг хэвлэсэн нь харьцангуй амжилттай болсон боловч цаашид хүчингүй саналын хуудсыг багасгах боломжтой. Тойргоос болон намын жагсаалтаар нэр дэвшигчдийг ийнхүү саналын нэг хуудсанд хэвлэж тэмдэглэгээ хийсэн нь зарим сонгогчийг төөрөгдүүлсэн гэх мэдээлэл байна.

Санал хураахад нэвтрүүлсэн өөр нэг шинэ зүйл нь сонгуулийн ил тод байдлыг хангах зорилгоор камержуулсан явдал байв. Гэхдээ улс төрийн намууд бичлэгийг сонгогчдыг сүрдүүлэх, саналаа хэрхэн өгч байгааг нь ажиглах арга хэрэгсэл болгосон хэмээн тайлбарлах хүмүүс байна.

Шинэтгэлийн үр дүнд нэг хэсэгт санал өгөх хүний тоо 2008 онд 1600 хүртэл байсан бол 2012 онд 1900 хүртэл болж өсчээ. Сонгогчид шинэ хэсэг рүү шилжсэн нь зарим хүний хувьд төөрөгдөл үүсгэсэн байж болох юм. Санал өгөх байртай холбоотой бусад асуудал нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд орох боломжгүй, урт дараалал үүссэн, санал өгөх бүхээггүй байсан зэрэг нь саналын нууцлалыг алдагдуулах магадлалтай гэх шүүмжлэл байв. Цаашид шинэ хуулиар саналын хуудсыг далдлах, намуудын төлөөлөл, ажиглагчдыг санал тоолох машинаас 3-4 метр хол зайд байлгах зэрэг асуудлыг зохицуулж болно.

СЕХ сонгуулийг зохион байгуулахдаа хуульд зааснаар намын төлөөлөл бус, төрийн албан хаагчдыг дайчлан ажиллуулсан нь бие даасан байдал, шударга ажиллагааг хангахад том алхам болжээ.

## **2.7. Сонгогчдын ирц**

Сонгуулийн шинэчлэл нь 2012 онд илүү оролцоо, төлөөлөлтэй парламент бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулсан боловч сонгогчдын ирц сүүлийн 10 жилд тогтмол буурч иржээ. Өмнөх сонгуулиуд амралтын өдөр болдог байсан бол 2012 оны сонгуульд сонгогчдын ирцийг нэмэгдүүлэх зорилгоор ажлын өдөр - Пүрэв гаригт зохион байгуулж, энэ өдрийг нийтийн амралтын өдөр болгон зарласан боловч сонгогчдын ирц буурсан дүн гарчээ.

Хүснэгт 1: УИХ-ын сонгуулийн сонгогчдын ирц

| Жил  | Сонгогчдын ирц |
|------|----------------|
| 1992 | 95.6%          |
| 1996 | 92.1%          |
| 2000 | 82.4%          |
| 2004 | 80.6%          |
| 2008 | 76.5%          |
| 2012 | 67.3%          |

Ардчилал тогтсоноос хойших 6 удаагийн сонгуулийн хувьд 1992 онд 96 хувьтай байсан сонгогчдын ирц тогтмол буурах хандлагатай байсан боловч энэ онд өмнөх сонгуулиас хамгийн огцом буюу 9.2 хувиар буурчээ. УИХ-ын сонгуулийн өмнө 6 сард явуулсан санал асуулгаар Улаанбаатар хотын сонгогчдын 75 хувь, хөдөө орон нутгийн сонгогчдын 88 хувь нь саналаа өгнө гэсэн дүн гарч байсан бол сонгуулийн өдөр 65 хувь нь л саналаа өгсөн байна.

НҮБХХ сонгогчдын боловсролд чиглэсэн материал, сурталчилгааны зурагт хуудас хэвлэж тараах, цахим хуудас шинэчлэх, телевизийн сурталчилгаа явуулахад СЕХ-нд дэмжлэг үзүүлсэн. Сонгуулийн шинэ тогтолцоо, саналын хуудас, санал тоолох автомат машины талаархи сонгогчдын мэдлэг ирцэд нөлөөлсөн гэж үзэх үндэслэл бага байна. Харин ирц бага байсан нь сонгуулийг ажлын өдөр зохион байгуулсан, санал авах ажиллагааг 22.00 цагаас 20.00 цаг болгож урагшлуулсан, сонгуулийн сурталчилгааны хугацааг 30 өдөр болгож богиносгосон, бүртгэл, санал авах ажиллагаа зэрэг илүү зохион байгуулалттай холбоотой байж болно.

Шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн, иргэд, ялангуяа залуучуудын ерөнхий иргэний идэвх суларсан, уул уурхайн салбарын огцом өсөлтийн үр дүнд өнгөрсөн жил гэхэд эдийн засаг 17 хувиар өссөн байхад иргэдийн аж амьдралыг дээшлүүлэх амлалтаа биелүүлж чадаагүй улс төрийн намуудад итгэх олон нийтийн итгэл улам бүр буурсаар байгаа нь сонгогчдын ирц сул байгааг тайлбарлах шалтгаан байж болно.

Улс төрийн намууд сонгуульд ялагдсанаа сонгуулийн луйвар, авлигатай холбон тайлбарлах гэж оролддог нь зохисгүй юм. Дайралт хийсэн ийм мэдэгдлүүд нь ерөнхийдөө тодорхой бус, нотолгоогүй байдаг. Иймэрхүү мэдэгдэл нь сонгуулийн үйл явцад итгэх итгэлийг бууруулахаас гадна сонгогчдын ирц доогуур байгаад нөлөөлөх нэг шалтгаан байж болно.

## **2.8. Гадаад улсад байгаа иргэдийн саналыг авах**

“Гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэд сонгуульд оролцох, тэдний саналыг авах тухай” журмыг Гадаад харилцааны яам, СЕХ-ны хамтарсан тушаалаар 2012 оны 4 сарын 30-нд баталсан. Засгийн газар гадаад улсад байгаа иргэдийн саналыг авах зохион байгуулалтын ажилд зориулж төсвөөс 300 сая төгрөгийн төсөв олгосон. Гадаадад суугаа нийт 80,000 сонгогчийн 4,320 нь санал өгөхөөр бүртгүүлж, 2,779 нь 2012 оны 6 дугаар сарын 10-нд хилийн чанад дахь Монгол Улсын Элчин сайдын яам, консулын газруудад зохион байгуулсан анхны санал хураах ажиллагаанд оролцож саналаа өгчээ. Саналыг 2012 оны 6 дугаар сарын 28-нд тоолсон бөгөөд ямар нэгэн зөрчил гараагүй байна. Сонгогчдын ирц сонгуулийн эрх бүхий иргэдийн 3.5 хувь байсан нь чамлалттай үзүүлэлт юм. Цаашид гадаад улсад байгаа монгол иргэдтэй сонгуульд оролцоход үүсч буй саад тотгорын талаар зөвлөлдөх нь зүйтэй.

## **2.9. Санал тоолох ажиллагаа**

2008 оны сонгуульд санал тоолох ажиллагаа, сонгуулийн дүнд үл итгэх байдал маш өндөр байсан нь сонгуулийн дараах өдрүүдэд үймээн самуун үүсэхэд нөлөөлжээ. Энэ асуудлыг шийдвэрлэх, будлиан гарах боломжийг хаах зорилгоор санал тоолох автомат машиныг ашигласан. Үүний зэрэгцээ санал тоолох автомат машинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, ил тод байдлыг хангахын тулд сонгуулийн тойрог бүрээс хоёр хэсгийг санамсаргүй сонгон авч, хяналтын тооллогыг гараар хийж, машины дүнтэй тулгалт хийжээ. Зөрүү маш бага гарсан ч ялагдсан намууд өөрсдийн сурталчилгаанд буруу өгөхийн оронд санал тоолох машин, түүний програм хангамжид бурууг тохих хандлагатай байв. Харин сонгогчид намуудаас илүү машинд итгэж байгаа нь харагдав.

Сонгуулийн урьдчилсан дүн гарч эхэлмэгц зарим нам луйвар хийж байгаа тухай болон машины програм хангамжийн талаар хардалт сэрдэлт хийн мэдэгдэл хийж, саналын хуудсыг бүх тойрогт гараар тоолоход хүрсэн. Бүх машины дүн таарсан нь машины програм хангамжийг өөрчлөөгүй болохыг харуулж байна. Дүн ийм гарсан боловч шинэ технологид итгэх итгэл сул, сонгуулийн ажилтнууд, намын гишүүд машиныг хялбархан өөрчилж чадна гэсэн ойлголт оршсоор байна. Гэвч санал тооллогын дүн бодитой гэдгийг гараар тоолсон дүн нотолж, 2008 оныхтой харьцуулахад санал тоолох ажиллагаа маш хурдан болохыг харууллаа.

Нийтдээ хүчингүй болсон саналын хуудас 3.6%-5% байсан бөгөөд машиныг ашиглаж сурснаар энэ хувь багасах боломжтой. Бүхэлдээ санал тоолох ажиллагаа 2008 оныхоос хамаагүй илүү шударга байсан учраас улс төрийн намуудын шинэ технологид итгэх итгэл нэмэгдэнэ хэмээн найдаж байна.

## **2.10. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх үйл явц**

Сонгуулийн дараа Монгол улсын УИХ-д дөрвөн (СЕХ 72 гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрүүлэхээр өргөн барьсан) суудал эзэнгүй байв. Зарим тойрогт дахин санал хураалт зарлахаар хүлээгдсэн бол зарим тойрогт хууль зөрчсөн үндэслэлээр маргаан үүсч маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа удаан хугацаагаар үргэлжилжээ. Ийнхүү маргаан удааширч, парламентын суудал хоосон байх нь сонгуулийн үйл явцад итгэх итгэлийг бууруулах сөрөг үр дагавартай.

Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг сайжруулахын тулд Захиргааны шүүх, Үндсэн хуулийн цэцийн эрх үүргийг зааглан тодорхой болгох хуулийн зохицуулалт хийх, гомдол гаргах журмын талаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, СЕХ-ны үүргийг илүү тодорхой болгох шаардлагатай байна.



## **2.11. Сөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх**

Шинэчлэлийн үр дүнд өмнөх сонгуулиудын үеэр сонгогчдын бухимдлыг төрүүлж байсан олон асуудлын шийдлийг олж, 2012 оны сонгууль будлиангүй, тайван боллоо. Бүртгэл, маргаан, сонгуулийн сурталчилгааны санхүүжилттэй холбоотой асуудлууд гарсан хэдий ч улс төрийн намууд, бусад холбогдох талууд сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрч байна. Өнгөрсөн сонгуулийн амжилтыг бататгахын тулд цаашид шинэчлэл шаардлагатай. Сонгуулийн үйл ажиллагаанаас илүү авлига, ажилгүйдлийн асуудал, үйлчилгээ хангалтгүй байдал нь нийгмийн тайван бус байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг. Эдгээр суурь шалтгааныг шийдвэрлэхгүй бол сонгууль нь иргэдийн бухимдлаа илэрхийлэх хэрэгсэл болдог.

## **2.12. Хэвлэл мэдээлэл**

Сонгуулийн сурталчилгаанд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг сүүлийн жилүүдэд улам бүр нэмэгдсээр байна. Улс төрийн намууд сонгуулийн сурталчилгаандаа төлбөртэй ба төлбөргүй хэвлэл мэдээлэл аль алиныг нь ашигладаг. МҮОНРТ СЕХ-ны гаргасан хуваарийн дагуу сонгуулийн сурталчилгаатай холбогдсон нэвтрүүлгийг үнэ төлбөргүй нэвтрүүлсэн бөгөөд бүх улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчид тэнцвэртэй үйлчилжээ.

Хувийн радио, телевизээр нэвтрүүлж байгаа сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт хоёр цагаас илүүгүй байхаар заасан боловч сурталчилгааны цагийг хэтрүүлсэн тохиолдлууд гарчээ. Хувийн радио, телевиз гол төлөв бизнес, улс төрийн төлөөлөгч-ээдийн үзэл бодлыг илэрхийлдэг учраас иймэрхүү хязгаарлалт тогтоох нь чухал ач холбогдолтой юм. Сурталчилгааны хугацааг 30 хоног болгосноор зардал багасна гэж тооцоолсон боловч нэгжийн өртөг нь улам өссөн дүн гарчээ. Харин сурталчилгааны хугацаа богиноссон нь сонгогчдыг залхаахгүй байх давуу талтай.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мониторинг хийх, ялангуяа сонгуулийн өмнө нээгдээд дараа нь хаагдчихдаг шинэ телевизүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих зохицуулалт шаардлагатай байна. Нэвтрүүлгийн үнэ үлэмж нэмэгдсэнээр улс төрийн намууд, мөнгөтэй нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаанд зориулсан телевизийн хувийн суваг бий болгох сонирхлыг төрүүлэх хөшүүрэг болж болох юм. Энэ нь хэвлэлийн эрх чөлөө, олон ургалч байдалд сөргөөр нөлөөлөх болно. Монголын сонгогчид телевизээр олон харсан хүнээ сонгох хандлагатай байдаг тул олонд танигдсан байдал нь тэдний сонголтод нөлөөлдөг.

### **2.13. Төрийн бус байгууллагын мониторинг**

Төрийн бус байгууллагууд анх удаа сонгуулийн хороод, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ хийх эрхтэй болсон. Өмнөх сонгуулиудын үеэр тэд зөвхөн сонгуулийн өмнөх үе шат буюу сонгогчдын урьдчилсан жагсаалт, сонгуулийн сурталчилгаанд хяналт тавих боломжтой байсан. ТББ-ын энэ оролцоо нь өмнөх сонгуулиудын үеэр гарсан булхай, луйврын талаарх ойлголтыг залруулах, ардчилсан үйл явцад итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болжээ.

СЕХ-ноос ТББ-ын сонгуулийн үйл ажиллагаанд мониторинг хийх харилцааг зохицуулсан журмыг Иргэний нийгмийн хяналт сүлжээний саналд үндэслэн боловсруулж мөрдөн ажиллажээ. Уг ажил нь Монгол Улсад анх удаа хийгдсэн учир ТББ-уудыг нэгдсэн зохион байгуулалтад оруулахад хүндрэлтэй байв .

Цаашид тойргийн болон хэсгийн хорооны ажилтнуудын ТББ-ын мониторингийн үүргийн талаархи ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээллийг саадгүй өгч байхад анхаарах хэрэгтэй. ТББ-ууд өөрсдийн сүлжээ, зохицуулалт хийх механизмтай ч шинэ болон хөдөө орон нутаг дахь ТББ-уудыг мониторингийн ажиллагаанд татан оролцуулахын тулд илүү нээлттэй болгох шаардлагатай байна.

### **2.14. Орон нутгийн сонгууль**

Орон нутгийн сонгууль 2012 оны 11 дүгээр сарын 21-нд болсон. Энэ сонгууль УИХ-ын сонгуулийн нэгэн адил холимог паралель тогтолцоогоор явагдсан. УИХ-ын сонгуулиас ялгаатай нь нийт сонгогч анх удаагаа ухаалаг үнэмлэх ашиглан сонгуульд оролцов. Орон нутгийн сонгуулийн хууль болон бусад бэлтгэл дутуу байснаас хугацаа нь нэг сараар хойшлогдсон бөгөөд хүн амын зарим хэсэг тухайлбал малчид өвөлжөө рүүгээ нүүж, сонгогчдын ирцэд нөлөөлж болох талаар зарим хүмүүс сануулж байв. Нөгөөтэйгүүр, хугацаа хойшлогдсон нь улс төрийн намууд, бие дааж нэр дэвшигчид сонгогчдын дэмжлэг авах бодлогоо боловсруулахад нь боломж олгосон гэж үзэж болно. Сонгуулийн албан ёсны дүнг сум, аймаг, дүүргээс ажлын 5 өдөрт багтаан ирүүлж, эцсийн дүнг 7 хоногийн дотор зарлах ёстой, албан ёсны дүн хараахан зарлагдаагүй байна. СЕХ-ны урьдчилсан мэдээгээр сонгогчдын ирц аймгуудад 50 орчим хувь, улсын хэмжээнд 52.9 хувь, Улаанбаатар хотод 45.63 хувьтай байв.

Энэ удаагийн орон нутгийн сонгуульд улс төрийн намууд, бие дааж нэр дэвшигчид ихээхэн анхаарал тавьсан нь төсвийн шинэ хууль гарсантай холбоотой байж болох юм. Төсвийн шинэ хуулиар 2013 оноос орон нутгийн мэдэлд зарцуулах хөрөнгийн хэмжээ ихээхэн нэмэгдэж байгаа юм.

Орон нутгийн сонгуулийн ирц доогуур байдаг нь дэлхий нийтэд түгээмэл боловч орон нутгийг удирдах, төсвийг захиран зарцуулах хүнийг сонгох шийдвэр гаргахад идэвхтэй оролцохыг сонгогчдод уриалах хэрэгтэй.

## **2.15. НҮБХХ-ийн үүрэг**

Ярилцлага өгсөн бүх хүн НҮБХХ-ийн гүйцэтгэсэн үүрэг, 2010-2011 онуудад хэрэгжүүлсэн “Сонгуулийн тогтолцоогоор дамжуулан төлөөлөл, оролцоог хангах нь” төслөөр дамжуулан сонгуулийн шинэчлэлд үзүүлсэн дэмжлэг Монгол улсын улс төрийн шинэчлэлийн чухал үед үнэтэй хувь нэмэр оруулсныг өндрөөр үнэлж байв. Энэ төслийн дараагийн шатыг 2013-2016 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд сонгуулийн сургамжийг судалсан энэ илтгэлд гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, олсон ололтыг бататгах зорилт тавьж байна. Тодруулбал, сонгуулийн болон улс төрийн шинэчлэлийн талаарх техникийн мэдлэгийг нэмэгдүүлэх, оролцоо болон жендэрийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, улс төрийн амьдралд идэвхтэй оролцох иргэдийн чадавхийг бэхжүүлэх талаар УИХ-тай хамтран ажиллана.

НҮБХХ-өөс 2011 онд Манила хотод сонгуулийн сэдвээр зохион байгуулсан Бүсийн бага хурал, 2012 онд Бангкок хотод зохион байгуулсан Сонгуульт албан тушаалд улс төрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг боловсруулсан Бүсийн семинар зэрэг арга хэмжээ нь оролцогчдоос эерэг үнэлгээ авч, эдгээрээс урам авсан Монголын удирдагчид шинэчлэлийг урагшлуулах тодорхой алхмуудыг авч хэрэгжүүлж байна.

НҮБХХ үзүүлж байгаа дэмжлэг, ялангуяа угаасаа улс төрийн шинж чанартай хуулийн төсөлд зөвлөгөө өгөхдөө мэдрэмжтэй хандаж, гадаадын аливаа нөлөөлөл хийх гэсэн ойлголт бий болохоос сэргийлэх хэрэгтэй. Гэхдээ төрөл бүрийн семинар, ярилцлага уулзалтаар дамжуулан сайн туршлагыг дэлгэрүүлэх, жендэрийн эрх тэгш байдал зэрэг асуудлаар хэлцэл хийх боломжтой.

## **3. ДҮГНЭЛТ**

Монгол улс ардчиллыг түргэн хөгжүүлж сүүлийн 10 жилд ихээхэн амжилтад хүрсэн бөгөөд олон улсын ардчилсан нийгэмлэгийн гишүүн орон болж, бүс нутгийн хурлуудад идэвхтэй оролцож, Эрх чөлөөний ордон (Freedom House) зэрэг ардчиллын хэмжүүрээр чөлөөт ардчилалтай орон гэсэн үнэлэлт авчээ.

Монгол улс цаашид хууль эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх, ардчиллын институци ба үйл явц, хяналт, хяналт-тэнцвэрийн тогтолцоог бэхжүүлэх, улс төрийн болон санал өгөх үйл явцад иргэний оролцоог гүнзгийрүүлэх, асуудлыг илүү оролцоотойгоор зөвлөлдөх замаар ардчиллын эдгээр ололтыг улам бэхжүүлж үр дүнг нь тогтвортой хадгалах нь чухал юм. Дараах

асуудлуудыг нэн тэргүүний ээлжинд шийдвэрлэх шаардлагатай байна.

Холбогдох бүх хууль тогтоомжийг сонгуулийн нэгдсэн хууль болгон нэгтгэх нь холбогдох талууд үйлчлэх дүрэм журмын талаар нэгдсэн ойлголттой болж, тогтвортой байдал бий болгоход тустай байх болно.

Улс төрийн намууд ялахын тулд сонгогчдын саналыг татахыг чухалчилж, ялагдахаараа сонгууль будлиантай боллоо хэмээн маргаан үүсгэх хандлагатай байдаг. Сонгогчдын ирцийг цаашид бууруулахгүй байх илүү эрчимтэй арга хэмжээ авч, эх орондоо болон гадаад улсад байгаа иргэдийн бүртгэлд учирч буй саад тотгорыг арилгах, залуучуудын улс төрийн идэвхийг сэргээх замаар сонгогчдын ирцийг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Улс төрийн намуудаас илүү олон эмэгтэйг нэр дэвшүүлэх явдлыг дэмжих, нэр дэвших квотыг 30 хувьд хүргэхийн зэрэгцээ тэднийг жагсаалтад сонгогдох боломжтойгоор байрлуулах (zebra/zipper), сонгогдох эрхэд ялгавар тогтоож байгаа нэр дэвшигчийн татвараас зайлсхийх хэрэгтэй. Эмэгтэй нэр дэвшигчид сурталчилгаа явуулахад өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, сонгогчид, хэвлэл мэдээлэл, парламентын эрэгтэй гишүүд, намын гишүүдийн хандлагыг өөрчилж, улс төрийн үйл хэрэгт оролцож буй эрэгтэй, эмэгтэй аль ч хүмүүс улс орны хөгжил дэвшилд тэгш хувь нэмэр оруулдаг болохыг харуулах хэрэгтэй.

Хэрэгжүүлсэн шинэтгэл, шинэ санааны үр дүнд УИХ-ын 2012 оны сонгууль зохион байгуулалт сайтай, тайван болж, Монгол улсын ардчиллын хөгжилд томоохон дэвшил гарч байгааг харуулсан үйл явдал боллоо. Хэдий сонгууль ийнхүү тайван болж өнгөрсөн ч зарим тайланд дурдсанаар сонгуулийн шинэчлэл нь улс төрийн институци, намуудад итгэх иргэдийн итгэлийг бий болгож чадаагүй байна.

#### **4. СУРГАМЖ**

- Ихээхэн шинэчлэл бүхий хуулийг сонгуультай ойртуулж баталсан учраас зарим зохион байгуулалт дутуу хийгдэж (ухаалаг иргэний үнэмлэхийг тараах гэх мэт), үр дүнтэй сонгогчдын боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх, иргэдтэй зөвлөлдөх хугацаа бага үлдсэн.
- Сонгуулийн холимог паралель тогтолцоог авснаар оролцоог нэмэгдүүлэхийг зорьсон боловч эмэгтэйчүүд, жижиг намууд, бие даан нэр дэвшигчдийн төлөөлөлд төдийлөн ахиц гараагүй.
- Намуудын авсан саналаар эмэгтэй нэр дэвшигчид сонгогдох боломж нэмэгдсэн ч намын дотоод хуваагдал нь цөөн эмэгтэй сонгогдоход нөлөөлсөн байж болно. Үүний нэг адилаар эмэгтэй нэр дэвшигчид тойрогт дангаараа өрсөлдөхийн оронд олон мандаттай тойрогт

эрэгтэй нэр дэвшигчтэй баг болж өрсөлдөх нь тэдэнд илүү сонгогдох боломж олгоно.

- Нэр дэвших тэгш боломжийг хангахад хамгийн том саад тотгор нь нэр дэвшигчийн татвар, санхүүжилт босгох шаардлага байсан.
- Улс төрийн санхүүжилтийн тухай хуульд сонгуулийн кампанит ажлын санхүүжилт босгох арга замын тухай тодорхой заалт байхгүй, харин зардлыг хэрхэн зарцуулах тухайд заалтууд бий. Зардлыг хязгаарлах заалтууд сул байгаа нь хөрөнгөтэй нэр дэвшигчид, улс төрийн намуудад илүү боломж олгож; хяналт тавих ба хууль мөрдүүлэх механизм сул байгаа нь намууд, нэр дэвшигчид сонгогдсоныхоо дараа бизнесийн ашиг сонирхолд автагдах эрсдэлийг бий болгоно.
- СЕХ санхүүгийн хяналтын хороогоороо дамжуулан сонгуулийн сурталчилгааны санхүүжилтэд хяналт тавих үүрэгтэй, холбогдох хөрөнгө нөөцтэй байдаг боловч улс төрийн намуудаас санал болгосон төлөөлөл нь энэ үүргийг үр нөлөөтэй гүйцэтгэхэд саад болдог.
- Бэлэн мөнгө тараасан зэрэг үйлдлийг мэдээлсэн сонгогчид мөнгөн урамшуулал олгох зэрэг заалт оруулсан хэдий ч ажилгүйдэл өндөр, цалин бага байгаа нөхцөлд санал худалдаж авах үзэгдлийг бүрмөсөн арилгах хүндрэлтэй юм. СЕХ эдгээр үйлдэлд хатуу арга хэмжээ авснаар улс төрийн намуудад цаашид ийм үйлдэл хийхгүй байх хүчтэй анхааруулга болж байна.
- Хүн амын 2010 оны тооллого, иргэний шинэчилсэн бүртгэлийн үр дүнд сонгогчдын бүртгэл сайжирсан бөгөөд үүнийг иргэний шинэ үнэмлэхтэй холбосон.
- Иргэний боловсролыг системтэй олгох үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь сонгогчдын ирц доогуур байх, ерөнхийдөө гадуурхагдсан сэтгэгдэл төрүүлэхэд нөлөөлсөн байж болно.
- Санал тоолох автомат машин зэрэг шинэ технологи нэвтрүүлэхэд холбогдох бүх талын бүрэн итгэлийг авахын зэрэгцээ сонгуулийн үйл явц, дүнгийн талаар аливаа эргэлзээг тайлсан байх нь чухал.
- Саналыг сугалаагаар сонгон авч гараар тоолсноор зөрүү маш бага гарсан нь автомат машинд итгэх итгэлийг бий болгож, эргэлзээг багасгахад ач холбогдолтой болсон.
- Ногдуулах шийтгэл хууль зөрчсөн үйлдэлтэй харьцангуй хэт хатуу байх нь түүнийг мөрдүүлэхэд төвөгтэй болох нь харагдлаа.
- Маргааны улмаас парламентын зарим суудал хоосон байгаа асуудлыг түргэн шийдвэрлэхгүй бол сонгуулийн хууль ёсны байдалд нөлөөлөх эрсдэлтэй.
- НҮБХХ парламентын хөгжил, сонгуулийн үйл явцад дэмжлэг үзүүлэх замаар чухал үүрэг гүйцэтгэдэг боловч зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэрэг эдгээр “зөөлөн тусламж”-ийн хувьд нэг талаас хүлээн авагч тал тусламж авснаа тэр бүр мэдээлдэггүй, нөгөө талаас гадаадын нөлөө орж буй гэсэн болгоомжлолын үүднээс НҮБХХ-өөс зохион байгуулж буй үйл ажиллагаа, үр дүн хэмээн тэр бүр ил тод зарладаггүй байна.

## 5. ЗӨВЛӨМЖ

- Ардчилсан засаглалыг төлөвшүүлэхэд чиглэсэн авлигатай тэмцэх, захиргааны болон төрийн албаны шинэчлэл, төвлөрлийг сааруулах бодлого, жендэрийн тэгш байдал бий болгох зэрэг бусад өөрчлөлт шинэчлэлийн уялдааг хангах шаардлагатай.
- Бүх хууль тогтоомжийг шинэчилж Сонгуулийн нэгдсэн хуультай болох нь тогтвортой байдал, урьдаас тодорхой байдлыг нэмэгдүүлж, холбогдох талууд хуулийн хүрээнд илүү үр нөлөөтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Эрх барьж буй эвсэл шинэтгэлийн үйл явц дахь сөрөг хүчин болон бусад талуудын байр суурийг орхигдуулж болохгүй. Холбогдох бүх талтай зөвлөлдөх нь шинэтгэлийг бататгах, үндэсний зөвшилцөл бий болгох, зөрчилдөөнөөс сэргийлэх ач холбогдолтой.
- Сонгуулийн тогтолцооны пропорциональ элемент дэх суудлын тоог нэмэгдүүлэх, улс төрийн намын хуульд эмэгтэйчүүдийн квотыг 20-с 30 хувь болгох, намын нэрийн жагсаалтад эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчдийг солбицуулж байрлуулах зэрэг сонгуулийн шинэчлэлийг үргэлжлүүлэн хийх замаар 2012 оны сонгуульд эмэгтэйчүүдийн үзүүлсэн амжилтыг бататгах;
- Шинээр сонгогдсон эмэгтэй гишүүдийн чадавхийг бэхжүүлэх, УИХ-ын бүх гишүүдийн жендэрийн тухай ойлголтыг нэмэгдүүлэх замаар шинэ гишүүдийн талаарх олон нийтийн хүлээлтийг бататгаж парламентын төлөөллийн чанарыг сайжруулах;
- Хэвлэл мэдээллийг зохицуулах асуудлыг цаашид авч үзэх, ялангуяа сонгуулийн өмнө хөрөнгө мөнгөтэй нэр дэвшигчид санхүүжүүлж, тэгш бус сурталчилгаа хийж буй сүүлийн үеийн хандлагад тусгай анхаарал хандуулах;
- Нэр дэвшигчдэд тэгш боломж олгохын тулд сонгуулийн сурталчилгааны зардлыг бууруулах, улс төрийн намууд, нэр дэвшигчдэд тодорхой шалгуур дээр үндэслэн улсын төсвөөс санхүүжилт олгох асуудлыг авч үзэх;
- Сонгогчдын саналыг татах зорилгоор бэлэн мөнгө тараах, элдэв амлалт авах явдлыг жигшүүлсэн, саналын ач холбогдлыг тайлбарласан утгатай сонгогчдын боловсролын хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, улс төрийн намууд шударга өрсөлдөөнийг эрхэмлэж ёс зүйн гэрээнд гарын үсэг зурах, санал худалдан авах явдлыг олны өмнө зарлан буруушаах, улс төрийн намууд хууль зөрчих явдлыг зогсоох зорилгоор хуулийг чанд мөрдүүлэх;
- Сонгогчийн мэдээлэл, ялангуяа хаягийг тогтмол шинэчилж байх, шилжин ирсэн сонгогчдод тэдний эрх, хаягийн шилжилт хийх журмыг тайлбарлаж байх;
- Дараагийн сонгуулиудад сонгогчдын ирцийг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын болон гадаад улсад байгаа сонгогчдод санал өгөхөд учирч буй саад тотгорыг тодорхойлох санал асуулга явуулах;

- Сонгуулийн бүх хэсэгт өндөр настай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд орж санал өгөх боломжийг хангах;
- Сонгуулийн шинэ ажилтнуудыг сургах, шинээр гарч байгаа өөрчлөлтүүдээр давтан сургалт хийх сургалтын стратеги боловсруулах, сонгуулийн тойрог, хэсгийн хорооны ажилтнуудын ажлын үр дүнд үнэлгээ хийж алдааг залруулах, нягт нямбай, шуурхай ажиллагааг дэмжих, сонгуулийн ажиглагчдын үүргийн талаарх хэсгийн хороодын ажилтнууд, улс төрийн намуудын мэдлэгийг дээшлүүлэх;
- СЕХ-нд зөрчилдөөнийг зохицуулах, урьдчилан сэргийлэх талаар сургалт явуулах, маргааныг хянан шийдвэрлэх тодорхой журам боловсруулах, СЕХ-ны хууль ёсны болон бие даасан байдлыг хангах, сонгуулийн хуулийг чанд сахиулж, хууль зөрчсөн үйлдэлд шийтгэл ногдуулж байх чиг үүргийг тодорхой болгох;
- Сонгуультай холбоотой мэдээллийг хэвлэж ил тод байдлыг хангах, саналын хуудсыг архивлах ажиллагааг сайжруулах;
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, УИХ-ын хууль тогтоох, төсөв батлах зэрэг сонгуулиас гадуурх үйл ажиллагаанд тавих иргэний нийгмийн хяналтыг нэмэгдүүлэх;
- Бүх сонгогч, үүний дотор залуучуудын идэвхийг сэргээх зорилгоор иргэний боловсрол, иргэний оролцооны үндэсний стратеги боловсруулах, залуучуудын оролцоог хангах, сургуулийн сургалтын хөтөлбөрт иргэний эрхийн тухай хичээлийг оруулах, хичээлийн үйл явцад сонгууль явуулах замаар ардчиллын соёлд суралцах явдлыг хөхиүлэн дэмжих;
- Иргэний боловсролын хөтөлбөрөөр дамжуулан шинэ хууль тогтоомж, эрх, үүргийн талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, иргэдтэй холбоотой тодорхой сэдвүүдээр хэлэлцүүлэг өрнүүлэх, нээлттэй сонсгол хийх;
- Судалгааны төв, номын сангаар хангах, чухал сэдвүүдээр семинар зохион байгуулах, хэрэгцээнд нь тулгуурлан экспертизийн үйлчилгээ үзүүлэх, туршлага солилцох аялал хийх, нээлттэй сонсгол зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлэх замаар УИХ-ын байнгын хороод, ажилтнууд, УИХ-ын шинэ гишүүдийн чадавхийг бэхжүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийх хэрэгтэй.

## ХАВСРАЛТ 1: ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН ХҮМҮҮС

Монгол улсын 2012 оны сонгуулийн сургамжийг судлах ажлыг 2012 оны 9 дүгээр сарын 22-ноос 10 дугаар сарын 3-ны хооронд НҮБХХ-ийн Ази, Номхон далайн бүсийн төвийн Сонгуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн Саймон Финлэй, НҮБХХ-ийн Нью Йорк дахь төвийн Жендэрийн зөвлөх Жулия Баллингтон нарын хамт төсөл боловсруулах ажлын хүрээнд бие даасан зөвлөх хийв.

Судалгаанд 30 шахам хүнтэй ярилцлага хийсэн бөгөөд тэд Улаанбаатар хот, Өвөрхангай аймаг, Олон улсын байгууллагын төлөөлөгчид байв.

Сонгуулийн Ерөнхий Хороо

1. Н. Лувсанжав, СЕХ-ны дарга
2. Ч. Содномцэрэн, СЕХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга

Улсын Их Хурал

3. С. Оюун, УИХ-ын гишүүн, Иргэний Зориг- Ногоон намын дарга
4. Р. Бурмаа, АН-аас сонгогдсон УИХ-ын гишүүн, Өргөдлийн Байнгын хорооны дарга
5. А. Бакей, УИХ-ын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга
6. О. Тунгалаг, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны зөвлөх
7. Ц. Оюунгэрэл, УИХ-ын гишүүн, АН-ын Эмэгтэйчүүдийн байгууллагын тэргүүн
8. Л. Эрдэнэчимэг, УИХ-ын гишүүн, УИХ дахь Эмэгтэйчүүдийн бүлгийн дарга

Ерөнхийлөгчийн Тамгын газар

9. Ч. Сосормаа, Ерөнхийлөгчийн зөвлөх

Засгийн газар

10. Б. Чинбат, УБЕГ-ын Мэдээлэл, технологийн газрын дарга
11. Б. Энхсайхан, Жендэрийн үндэсний Хорооны ажлын албаны дарга
12. Т. Гончигдорж, Өвөрхангай аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга, Сонгуулийн 10 дугаар тойргийн хорооны дарга асан

Улс төрийн намууд

13. Ж. Сүхбаатар, МАН-ын Нарийн бичгийн дарга
14. Б. Цаямаа, Өвөрхангай аймаг дахь МАХН-ын дарга
15. Ц.Хишигсүрэн, Өвөрхангай аймгийн Ардчилсан намын үүрийн дарга



#### Олон улсын байгууллагууд

16. Мелони Линдберг, АНУ-ын Азийн сангийн Суурин төлөөлөгч
17. Тирза Тиуниссан, Азийн сангийн жендэрийн асуудал хариуцсан зөвлөх
18. Рафаэл Бежар, Бүгд найрамдахчуудын Олон улсын хүрээлэнгийн Хөтөлбөрийн захирал
19. Х. Өрнөх, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн Хөтөлбөрийн ажилтан

#### Иргэний нийгэм

20. С.Оюунтуяа, Сонгогчдын боловсрол төвийн гүйцэтгэх захирал
21. Л. Сумати, Сант Марал сангийн захирал
22. Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан ТББ-ын Өвөрхангай аймаг дахь салбарын ажилтан.
23. П. Эрдэнэжаргал, Нээлттэй нийгэм Форумын Гүйцэтгэх захирал

#### Хэвлэл мэдээлэл

24. Б.Жаргалмаа. Ийгл телевизийн ерөнхий редактор

#### Нэгдсэн Үндэстний Байгууллага

25. Сезин Синаноглу, НҮБХХ-ийн Суурин төлөөлөгч
26. Аржентина Матавел Пичин, НҮБ-ын Хүн амын сангийн Суурин төлөөлөгч
27. Ц. Даваадулам, НҮБХХ-ийн Засаглалын багийн ахлагч
28. Л. Бархас, НҮБХХ-ийн Засаглалын асуудал хариуцсан мэргэжилтэн
29. Э. Гэрэлт-Од, НҮБХХ-ийн Сонгуулийн зохион байгуулалтанд дэмжлэг үзүүлэх Төслийн менежер

